



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/20

Мандалговь

**0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан
Хаагчдад цалинтай чөлөө олгож, богиносгосон
цагаар ажиллуулах тухай**

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын 7, 10, 11, Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгаврын 1 болон 3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2020 оны А/02 дугаар албан даалгаврын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвар тархахаас сэргийлэх зорилгоор 2020 оны 3 сарын 16-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл байгууллагын 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдад ажлын цагийн зохицуулалт хийж цалинтай чөлөө олгосугай.

2. 0-18 хүртэлх насны хүүхэдтэй бусад албан хаагчдыг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд өдөр бүр 10:00-13:00, 14:00-17:00 цаг хүртэл богиносгосон цагаар ажиллуулсугай.

3. Байгууллагын албан хаагчдын хүүхдийн насны судалгааг 1 дүгээр, байгууллагад ажиллах албан хаагчдын ажлын хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Нийт албан хаагчдын цалинтай чөлөө болон богиносгосон цагийг үндсэн цагаар ажилласанд тооцон цалинжуулахыг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

5. Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс өөрийн хүүхэд, гэр бүлийн хараа хяналтыг сайжруулан, аюулгүй байдлыг хангаж, албан үүргээ хууль тогтоомжийн дагуу чанартай гүйцэтгэн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190030